БАЯНХОНГОР АЙМГИЙН СУМ, БАЙГУУЛЛАГУУДЫН
2025 ОНЫ ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ХУУЛЬ
ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2026 оны 01 дүгээр сарын 08 Номгон

Нэг. Товч танилцуулга[1]
Баянхонгор аймгийн сум, байгууллагуудын хэмжээнд төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт нөлөөллийн арга хэмжээг давхардсан тоогоор 9644 албан хаагчдад хийж, 21 зөрчлийн талаар гомдол ирснийг шийдвэрлэж, 21 дүгнэлт гаргасан байна. Үүнээс дүн шинжилгээ хийхэд албан хаагчдын хоорондын таарамжгүй байдал, иргэдтэй зүй бус харилцах, иргэдийн хүсэлтэд хариу өгөхдөө хугацаанд нь шийдвэрлэхгүй байх зэрэг зөрчил давамгайлж байна.
Хоёр.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар
2.1.Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[2]:
Хяналт шинжилгээ үнэлгээгээр 20 сум, Архив, албан хэрэг хөтлөлт, ажлын зохион байгуулалтын улсын үзлэгээр 20 сум, 190 байгууллагын ёс зүйн дэд хороодын үйл ажиллагаатай танилцаж, зөвлөн туслах ажлыг зохион байгуулж, Монгол Улсын Их хурлын 2024 оны 27 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангах чиглэлээр төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллах, "Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналт" цахим систем-https://www.hrm.csc.gov.mn/-д төлөвлөгөө, ёс зүйн зөрчлийг бүртгэх талаар зөвлөмж, зөвлөгөө өгч ажиллалаа. Үүний хүрээнд сум, байгууллагууд үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.
2.2.Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал:
-Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахад орон нутгийн төсвөөс 4.0 сая төгрөг шийдвэрлэж, аймгийн хэмжээний үйл ажиллагаанд зарцуулан ажилласан. -Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 109 дүгээр "Төрийн захиргааны болон үйлчигээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ"-ний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Хөх өнгийн дэвсгэр бүхий тээврийн хэрэгсэл"-ийг төрийн албан хэрэгцээнд ашиглахыг уриалсан контентыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлан 11000 хүний хандалтыг тус тус авсан байна. -Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Улсын Их хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтийг хангах, сурталчлах, ёс зүйн дэд хороодын үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор **"ЁС ЗҮЙГЭЭР МАНЛАЙЛАГЧ"** байгууллага шалгаруулах болзолт уралдааныг 20 сумын Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд, ОНӨААТҮГ-уудын дунд зохион байгууллаа. -Болзолт уралдааны хүрээнд зохион байгуулсан Дэвжээ тэмцээнд Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар, Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Мал эмнэлгийн газар, Хөдөлмөр

[1] Байгууллагын харьяа салбар, нэгжийн хэмжээнд Төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээг сахиулах, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөрчил гаргасан эсэхийг хянан шалгаж, дүгнэлт гаргах, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд дүн шинжилгээ хийх байдлын талаар товч мэдээллийг тайлагнана.

[2] Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагааны талаар тайлагнана.

халамжийн үйлчилгээний газар, Байгаль орчны газар, Нийгмийн даатгалын газар, Стандарт хэмжил зүйн хэлтэс, Баянхонгор-Эрчим хүч ЦТ ХХК-ний ёс зүйн дэд хорооны гишүүд, албан хаагчдын төлөөллөөс бүрдсэн 10 баг оролцож, хурд хүч, авхаалж самбаа, оюун ухааны цар хүрээ, мэдрэмж, багийн ажиллагаагаар өрсөлдөж, Тэргүүн байранд Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газар, Дэд байранд Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газар, Гутгаар байранд Байгаль орчны газар, Тусгай байранд Стандарт хэмжил зүйн хэлтэс, Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар тус тус байр эзэлж, өргөмжлөл мөнгөн шагналаар шагналаа.

-Уралдааныг 2 сарын хугацаанд зохион байгуулснаар Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Улсын Их хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг олон нийтэд сурталчлах, төрийн албан хаагчдын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлж, бүтээлч хандлагыг нэмэгдүүлэн, нийт 59 удаагийн сургалтыг давхардсан тоогоор 2818 төрийн албан хаагчдад хийж, 52 постер, 14 контентыг бүтээж олон нийтийн сүлжээнд байршуулан сурталчлан ажилласан.

-Шинэжинст, Баянлиг, Баянхонгор, Өлзийт, Эрдэнэцогт, Хүрээмарал сумын Засаг дарга, Тамгын газрын даргын санаачилгаар сумын нийт төрийн албан хаагчийг хамруулан "Төрийн албан хаагчдын сахилга хариуцлагын зөвлөгөөн"-ийг зохион байгуулж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль тогтоомжоор сургалт, мэдээлэл хийж, эрх зүйн мэдлэг ойлголтыг нь нэмэгдүүлсэн.

2.3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа:

-Сум, байгууллагуудын ёс зүйн дэд хороо нь үйл ажиллагааны төлөвлөгөөг батлаж, хэрэгжилтийг ханган ажилласан байна.

Сум байгууллагын хэмжээнд ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулж, давхардсан тоогоор 5514 албан хаагчдад хамруулж ажилласан байна.

-Хууль тогтоомжийг сурталчлах төрийн байгууллага аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөвлөн туслах ажлыг аймгийн Засаг даргын 2025 оны 05 дугаар удирдамжийн хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 29-нөөс 05 дугаар сарын 01-ний өдрүүдэд Хүрээмарал, Баянбулаг, Бууцагаан, Бөмбөгөр сумдын 361 төрийн албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээгээр сургалт хийж, "Бид ёс зүйтэй төрийн албан хаагчид" челлэнжид 250 Төрийн албан хаагчдыг хамруулан ажиллалаа.

-Аймгийн Засаг дарга сум, байгууллагын удирдах албан тушаалтнуудтай хамтран ажиллах батламж олгон, авлигагүй ажиллах талаар 11 сумын 687, 13 агентлагийн 281, төсөвт 2 байгууллагын 13, цэцэрлэгийн 91 нийт 1072 албан тушаалтан авлига ашиг сонирхлоос ангид байх баталгаа гаргасан.

-Сум, байгууллагуудын ёс зүйн дэд хороо нь Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналт" цахим систем- https://www.hrm.csc.gov.mn/-д төлөвлөгөө, ёс зүйн зөрчлийг бүртгэх ажил тогтмолжсон байна.

Гарсан үр дүн, ололт амжилт:	Бэрхшээл:
Албан хаагчдыг соён гэгээрүүлэх, ёс зүй, сахилга, хариуцлагыг дээшлүүлэхсургалт нөлөөллийн арга хэмжээ тогтмолжсон Ёс зүйн хариуцлагыг бүртгэлжүүлсэн Эрх зүйн орчин сайжирсан.	Ёс зүйн дэд хорооны гишүүдийн ажлын ачаалал нэмэгдсэн Гишүүдэд урамшуулал олгохгүй байгаа.

Санал:
Ёс зүйн дэд хорооны гишүүдэд улирал тутам олгох урамшууллыг олгох асуудлыг тодорхой болгож шийдвэрлэх. Ёс зүйн дэд хорооны гишүүдийг чадвахжуулах сургалтыг жил бүр Монгол Улсын ёс зүйн дэд хорооноос танхимын болон цахим сургалтыг зохион байгуулах

БАТАЛГААЖУУЛАЛТ:
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ П.ОТГОНБАЯР

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА Ш.ГЭРЭЛСҮХ

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД
ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Д.ОТГОНТӨГС

БАЯНХОНГОР АЙМГИЙН СУМ, БАЙГУУЛЛАГУУДЫН 2025 ОНЫ "ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ"

2026 оны 01 дүгээр сарын 08 Номгон

№	Үзүүлэлт	Шалгуур үзүүлэлт		Авбал зохих оноо	Оноо[1]	Хувийн жин[2]
1	2	3		4	5	6
1	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт[3] (ҮХХ)	Үйл ажиллагааны төлөвлөгөөг шалгуур үзүүлэлттэй нийцүүлэн баталсан эсэх[4]		1	1	10
2		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилд өртөх эрсдэлийн үнэлгээ хийсэн эсэх [5]		1	0	0
3		Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлсэн байдал	Ёс зүйн сургалтыг 2-оос доошгүй удаа батлагдсан агуулгын хүрээнд зохион байгуулсан эсэх [6]	0.5	0.5	5
			Соён, гэгээрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулсан байдал[7]	0.5	0.5	5
			Ёс зүйн нөлөөллийн мэдүүлэг гаргасан байдал[8]	0.5	0	0
			Ёс зүйн зөрчлийн хариуцлагын бүртгэлийн маягт беглөсөн байдал[9]	0.5	0.5	5
Хэсгийн оноо				4	2.5	25
4	Томилох эрх бүхий албан тушаалтны ёс зүйн манлайлал (ЁЗМ)	Ёс зүйн дэд хорооны дүгнэлтийг үндэслэн шийдвэр гаргасан эсэх [10] *(гарсан дүгнэлтийн хувийн жингээр тооцох бөгөөд гомдол ирээгүй бол 1 оноо)*		1	0.5	5
5		Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан, зөрчлийн шийдвэрлэлтийг цахим хуудсанд байршуулсан байдал[11]		1	1	10
6		Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа, гишүүдийг урамшуулах санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэсэн байдал[12]		1	0	0
Хэсгийн оноо				3	1.5	15
7	Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагаа (ЁЗДХ)	Дэд хорооны бүрэлдэхүүн хөдөлгөөнийг бүртгэсэн байдал[13]		1	1	10
8		Төрийн албан хаагчаас ирүүлсэн гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн байдал [14] *(Гомдол ирээгүй бол 1 оноо авна, нийт ирүүлсэн өргөдөл, гомдлын хувийн жингээр тооцно)*		1	0.5	5
9		Ёс зүйн зөрчлийн бүртгэл, хяналтын дэд систем дэх дүгнэлт, шийдвэрийг бүртгэж, тайлагнасан байдал [15]		1	1	10
Хэсгийн оноо				3	2.5	25
Үнэлгээний нийт оноо, хувь				10	**6.5**	**65**

БАТЛАВ
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА Ш.ГЭРЭЛСҮХ

2025..оны..01..дүгээр сарын..15.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 01 дүгээр сарын 15

Номгон

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хугацаа	Хариуцах албан хаагч
1	2	3	4	5	6	7	8
1	Байгууллагын ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлуулах	-	Төлөвлөгөөний биелэлтийн хувь	100	100	1 сард	Д.Отгонтөгс
2	Ёс зүйн дэд хорооны хуралдах хуваарийг гаргаж батлуулах	-	Хурлын тоо	3	12	1 сард	Д.Отгонтөгс
3	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр /2024-2030/-ыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан батлуулах	-	Хэрэгжилтийн хувь	-	100	1-12 сар	Дарга, гишүүд
4	Хороонд ирсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэж, дүгнэлт, зөвлөмж гаргаж, томилох эрх бүхийн албан тушаалтанд хүргүүлэх	-	Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн хувь	100	100	Тухай бүр	Гишүүд
5	Ёс зүйн гомдол, мэдээлэл, зөрчил, хүлээлгэсэн хариуцлагын бүртгэлийг "Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо" цахим системд бүртгэх, үйл ажиллагаандаа тогтмол ашиглах	-	Тухай бүр цахимд бүртгэсэн байна.	-	100	Тухай бүр	Нарийн бичгийн дарга
6	Ёс зүйн дэд хороонд нэн шаардлагатай дуу хураагуур авах	500.0 Мян/төг	Гүйцэтгэлийн хувь	-	100	5 сард	Д.Отгонтөгс

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Д.ОТГОНТӨГС

БАТЛАВ
АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Д.ЭНХЖАРГАЛ
2025 оны 01 дүгээр сарын 15

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

2025 оны 01 дүгээр сарын 15

Номгон

д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хугацаа	Хариуцах албан хаагч
1	2	3	4	5	6	7	8
Төрийн албан хаагч ёс зүйтэй ажиллахад дэмжлэг үзүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг идэвхжүүлнэ.							
1	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээгээр байгууллагын албан хаагчдад сургалт хийж, постер бэлтгэж олон нийтэд түгээх	-	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо Постерын тоо	-	90 5	1-9 сард	Д.Отгонтөгс
2	Шинээр томилогдсон албан хаагчдад харилцаа хандлага ёс зүй сэдвээр сургалт зохион байгуулах	-	Сургалтад хамрагдсан албан хаагчдын тоо	15	10	3 сард	Ш.Гэрэлсүх
Төрийн албан хаагч ёс зүйтэй ажиллах орчин, нөхцөлийг бүрдүүлж, дэмжих арга хэрэгслийг өргөжүүлнэ.							
3	“Ёс зүйг эрхэмлэсэн хариуцлагатай төрийн албан хаагч” аяныг 2-10 сарын хугацаанд 20 сумын Засаг даргын Тамгын газар, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, ОНӨААТҮГ-ын албан хаагчдын дунд зохион байгуулах	-	Арга хэмжээний гүйцэтгэлийн хувь	-	100	2-10	Э.Батцэцэг

1	2	3	4	5	6	7	8
7	"Ёс зүйг эрхэмлэсэн хариуцлагатай төрийн албан хаагч" дэвжээ тэмцээн зохион байгуулах	2.7 сая/төг	Дэвжээ тэмцээнд оролцсон байгууллагын тоо	-	44	10 сард	Э.Батцэцэг Дарга, гишүүд
8	"Ёс зүйг эрхэмлэсэн хариуцлагатай төрийн албан хаагч" баннер АЗДТГ-ын үүдэнд байршуулах, самбар ажиллуулах	200.0 мян/төг	Гүйцэтгэлийн хувь	-	100	2	Д.Энхтуяа
9	Хэлтсийн дарга нарт Манлайлал чиглэлээр сургалт зохион байгуулах	-	Сургалтад хамрагдсан удирдлагын тоо	-	10	4 сард	М.Янжмаа
10	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар "Алтан хонх" тэмцээн зохион байгуулах	500.0 мян/төг	Хамрагдсан албан хаагчдын тоо	65	90	10 сард	Б.Булгамаа
11	Албан хаагчдын харилцаа ёс зүй, хандлагаар судалгаа авч, үр дүнг тооцох	-	Судалгаанд хамрагдсан албан хаагчдын тоо	55	60	11 сард	Т.Нороврinчин

ХЯНАСАН
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ
ДАРГА Ш.ГЭРЭЛСҮХ

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН
ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Д.ОТГОНТӨГС